


Skype for Business ашиглах заавар

Та Microsoft Office 365 үйлчилгээний эрхээ /цахим шууданд хандах эрх/ ашиглан Skype for Business үйлчилгээг ашиглах боломжтой. Энэхүү үйлчилгээ нь танд цахим ертөнцөд хэрэглэгчидтэй бүхий л төрлийн харилцаа, холбоо тогтоох боломжийг бий болгодог. Өөрөөр хэлбэл та бусад хэрэглэгчидтэй мессежээр харилцах, дуудлага хийх, дүрсээ харж ярилцах, ашиглаж буй програм эсвэл файлаа хуваалцан хамтран ажиллах, компьютерийн дэлгэцээ хуваалцах, МУИС-ийн бүх хэрэглэгчийг хайж олох, үүлзалт товлох боломжтой. Skype for Business програмын суулгацыг [эндээс](#) татаж авна уу.

Хандах эрх, нэвтрэх





Та тус програмыг хэрэглэхийн тулд юуны өмнө МУИС-ийн албан ёсны цахим шуудангийн хаягтай байх хэрэгтэй. “Skype for Business”-ийг татаж суулгасны дараа цахим шуудангийн хаяг болон нүүц үгээ ашиглан нэвтрэнэ.


/Жич: Шинээр хаяг нээлгэх, өмнөх хаягаа сэргээх бол МТА-нд хандана уу/

Хэрэглэгч хайх, шинэ хэрэглэгч нэмэх

Та МУИС-ийн албан ёсны цахим шуудангийн хаягтай нийт багш, ажилчид, оюутнуудаас хайлт хийх боломжтой. Үүний тулд хайлтын хэсэгт холбогдох хүнийхээ нэр эсвэл хаягийг бичснээр доод хэсэгт хайлтын үр дүн гарч ирнэ. Хэрэглэгчийн нэрэн дээр хулганы баруун товчийг дарж **Add to Contact List** –с зохих бүлгээ сонгон хэрэглэгчийг жагсаалтдаа нэмэх боломжтой.




Бүлэг хайх, бүлгийн хэрэглэгчдийг жагсаалтдаа нэмэх, шинэ бүлэг үүсгэх




Та МУИС-ийн салбар сургууль болон алба, хэлтсийн хэрэглэгчдийг бүлгээр нь өөрийн жагсаалтдаа нэмэх боломжтой. Үүний тулд бүлгийн нэрээр хайлт хийж хайлтын үр дүнд гарч ирсэн бүлгийн нэрэн дээр хулганы баруун товчийг дарж **Add to Contact List**-ийг сонгоно.

Мөн та шинээр бүлэг үүсгэн хэрэглэгчдээ ангилан нэмэх боломжтой. Шинэ бүлэг үүсгэхдээ **+** товч дээр дараад **Create New Group** –ийг сонгоно.



Харилцах



Та харилцах хэрэглэгчийнхээ нэрэн дээр 2 удаа товших эсвэл хулганы баруун товчийг дарж **Send to IM**-ийг сонгосноор харилцах цонх гарч ирнэ.

Дараах зургаас харилцах цонхны тайлбарыг харна уу.

